



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/119

Ховд

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ─┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Ариунбилэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Энхтайван - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Ж.Пүрэв-Очир - Иргэний төлөөлөл

Ц.Соёлмаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Д.Ариунбилэг/-д даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон/ -д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД